



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 190

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Өөрийн дотоод нөөц бололцоогоор барьж санхүүжүүлэн ашиглалтад оруулсан нийт 21,000,000.00 (хорин нэгэн сая) төгрөгийн үнэ бүхий автомашины гаражийг хавсралтад заасны дагуу Үйлдвэр урлалын политехник коллежийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Үйлдвэр урлалын политехник коллежийн захирал Д.Буяндэлгэр нарт тус тус дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Өөрсдийн дотоод нөөц бололцоогоор барьж санхүүжүүлэн бий болсон хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авч, бүртгэх;

2.2.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



132001470

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2021 оны 06 дугаар сарын 15-ны
өдрийн 00 дугаар тогтоолын хавсралт



Үйлдвэр урлалын политехник коллежийн хөрөнгөд
бүртгэх үл хөдлөх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр, байршил	Барилгын хүчин чадал	Гүйцэтгэлээрх дүн /төгрөгөөр/
1	Автомашины гаражийн барилга, /Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 10-р хороо сургуулийн хашаанд/	1 давхар, зооргүй, 72м2	21,000,000.00
	Нийт дүн		21,000,000.00 /хорин нэгэн сая/